


Эдийн засгийн улирлын өсөлт 5.6% (III улирал, оны үнээр)


ДНБ энэ оны эхний 3 улиралд оны үнээр 9.9 их наяд төгрөгт (7.1 тэрбум ам.доллар) хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 23.5%, харин 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3.9 их наяд төгрөг (2.8 тэрбум ам.доллар) болж, өнгөрсөн оны мөн үеэс 10.2% тус тус өссөн байна.

ДНБ-ий улирлын бодит өсөлт (оны үнээр) 5.6% хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 дахин бага үзүүлэлт байна.




Төсвийн алдагдал 0.6 их наяд төгрөг

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 12% өссөн бол зарлага түүнээс даруй 3 дахин хурдтай буюу 38% өссөн нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 558 тэрбум төгрөгийн (0.4 тэрбум ам.доллар) алдагдалтай гарахад хүргэлээ. Орлого нэмэгдэхэд НДШ 43%, НӨАТ 17%, ХАОАТ 47% тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин зарлага өсөхөд хөрөнгийн зардал 81%, татаас ба шилжүүлэг 33%, цалингийн зардал 45% өссөн нь нөлөөлөв.



Гадаад худалдааны алдагдал 2.0 тэрбум ам.доллар

Нийт барааны эргэлт энэ оны эхний 9 сарын байдлаар 8.5 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5% нэмэгдсэн байна. Экспорт 6.1% буурч, импорт 8.7% өссөнөөс гадаад худалдааны алдагдал 2.0 тэрбум ам.долларт хүрлээ. Нүүрсний экспорт өмнөх оныхоос 7%, зэс 16% тус тус буурсан бол төмрийн хүдрийн экспорт 27%, боловсруулаагүй газрын тос 33% нэмэгджээ. Импортын өсөлтөд дизель түлш 29%, автобензин 40%, суудлын автомашины импорт 13% өссөн нь голлон нөлөөлөв. Харин ачааны автомашины импорт 26%, шороо чулуу холих, ялгах машины импорт 30% буурчээ.



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч байна


Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 1,395 хүрч өмнөх сарынхаас 2.2%, өнгөрсөн оны мөн үеэс 10.7% тус тус суларлаа. Гадаад валютын нийт албан нөөц 2.8 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн сарынхаас 4.6%, өмнөх оны мөн үеэс 10.0% нэмэгдэв. V сараас эхлэн суларсан төгрөгийн ханш IX сарын сүүлчээс эхлэн бага зэрэг чангарах хандлага ажиглагдаж байна.



Инфляцын түвшин 14%-иас буухгүй байна

Улсын хэмжээгээр тооцсон жилийн инфляцын түвшин өмнөх сарынхаас 0.1 нэгжээр буурч 14.8% боллоо. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.3 нэгжээр өндөр үзүүлэлт юм.

Үнийн дундаж түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.8% нэмэгдэхэд согтууруулах ундаа, тамхины үнэ 49%, хүнсний барааны үнэ 22%, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний үнэ 24% өссөн нь голлон нөлөөлжээ.




Эх сурвалж: ҮСХ, МБ

САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ


Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө буурав

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 17.5%, өнгөрсөн сарынхаас 1.6% тус тус нэмэгдэж 7.1 их наяд төгрөгт (5.1 тэрбум ам.доллар) хүрчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 5.7% нэмэгдэж, өмнөх сарынхаас 8.5% буурч 0.7 их наяд төгрөг болсон нь нийт мөнгөний 10.5%-ийг эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд гадаад валютын хадгаламжийн өсөлт хамгийн их нөлөөлөв.




Гадаад валютын хадгаламж нэмэгдэж байна

Хадгаламжийн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 24.3%, өмнөх сарынхаас 3.7% тус тус нэмэгдэж 4.6 их наяд төгрөгт (3.3 тэрбум ам.доллар) хүрлээ. Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 10.5% өссөн бол валютынх 67.5% өсчээ. Харин өмнөх сарынхтай харьцуулахад төгрөгийн хадгаламж өөрчлөлтгүй, валютын хадгаламж 12.1% нэмэгдсэн байна. Төгрөгийн ханшийн сулралт буюу ам.долларын ханшийн өсөлттэй уялдан валютын хадгаламж ийнхүү өсч байна.



Зээлийн өрийн үлдэгдэл 6.9 их наяд төгрөг хүрэв

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 2.9%, өнгөрсөн оны мөн үеэс 35.7% нэмэгдэж, 6.9 их наяд төгрөг (4.9 тэрбум ам.доллар) боллоо. Чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 14%, өмнөх сарынхаас 1.9% буурч, нийт зээлд эзлэх хувь 4.5% хүрэв. Зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж) жилийн өмнөхтэй харьцуулахад төгрөгийнх 2.5, валютынх 2.1 нэгжээр тус тус өсчээ.



Эх сурвалж: ҮСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг танилцуулав.
- > УИХ-ын чуулганаар Монгол Улсын 2012 оны төсвийн тодотголыг баталлаа.
- > Засгийн газрын хуралдаанаар ойрын хоёр жилд Хөгжлийн банкны 5 тэрбум хүртэлх ам.долларын үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах талаар хэлэлцэж, эхний ээлжинд 1.5 тэрбум ам.долларын бонд гаргахаар шийдвэрлэв.
- > Засгийн газар архи, тамхинд ногдох онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх, мөн 0-18 насны хүүхэд бүрт, сар бүр 20 мянган төгрөгийн хүүхдийн мөнгө олгохоор шийдвэрлэв.
- > Дэлхийн эдийн засгийн форум "Дэлхийн өрсөлдөх чадварын индекс 2012" тайлангаа танилцуулав. Монгол улс 3.9 оноогоор 144 орноос 93-р байрт жагссан нь өмнөх оноос эрэмбэ ахисан (142 орноос 96) ч оноо ахиагүй байна.

Хураангуй

ДНБ эхний 3 улиралд оны үнээр 9.9 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 23.5% өсөлттэй байв. ҮСХ-ны урьдчилсан гүйцэтгэлээр 2012 оны ДНБ 14.2 их наяд төгрөгт хүрч, 12.4% өсөлттэй байхаар байна. Харин ОУВС манай улсын эдийн засгийг ойрын 4 жилд дунджаар 14% өснө гэж үзэж байсан ч гадаад зах зээлийн тогтворгүй байдлаас хамааран таамаглалыг бууруулж, 11.8% болгожээ. Улсын төсвийн алдагдал 0.6 их наяд төгрөг, гадаад худалдааны алдагдал 2.0 тэрбум ам.долларт хүрэв. Манай улс 2011 онд 21.3 сая тонн нүүрс экспортолж байсан бөгөөд энэ онд 30 гаруй сая тонн нүүрс экспортлох төлөвлөгөөтэй байсан. Гэвч Хятадын нүүрсний эрэлт багассанаас эхний 9 сарын байдлаар ердөө 14 сая тонныг борлуулсан бөгөөд энэ оны эцэс гэхэд 20 орчим сая тонн нүүрс экспортлохоор байна. VII, VIII сард жилийн эхний хагасын дундажтай харьцуулахад 2 дахин буураад байсан нүүрсний экспорт энэ сард сэргээд байгаа юм. Төгрөгийн ханш суларч, сарын дундаж ханш 1,395 болов. Гэхдээ сарын дундуур 1,402 болж оргилдоо хүрээд байсан ханш сарын сүүлчээр буурч 1,394, цаашлаад X сарын хагаст 1,380 болж чангарах хандлага ажиглагдаж эхэллээ. Хэрэглээний барааны үнийн дундаж түвшин өмнөх оны мөн үеэс 14.8%, өнгөрсөн сарынхаас 1% нэмэгдэв. Жилийн инфляц 14.8% хүрэхэд хүнсний барааны үнэ голлон нөлөөлжээ. Мөн онцгой албан татварын хувь хэмжээ нь нэмэгдсэн архи, тамхины үнийн өсөлт нөлөөлсөн байна. Монголбанк мөнгөний бодлогын төслийг танилцуулж инфляцыг нам түвшинд барих, нийлүүлэлтийн гаралтай инфляцыг Засгийн газартай хамтран хязгаарлах бодлого баримтлахаа мэдэгдэв. Монголбанкны болоод төрийн үйл ажиллагаа хоорондоо зөрчилдөхгүй байж чадвал хугацаа их шаардах хэдий ч энэ бодлого хэрэгжих боломжтой. Гэсэн ч зээлийн хүүг бууруулах талаар илүү тодорхой бодлого дутагдаж байна.